ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022 /18/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг:dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэл....................2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....................4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....................4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....................7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................10
3. Аудитын тайлан ....................10
3.1 Ерөнхий зүйл .................... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.................... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .................... 11
3.4 Материаллаг байдал .................... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .................... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .................... 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.................... 13
3.8 Аудитын гол асуудал .................... 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .................... 13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.................... 13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.................... 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.................... 14
4. Аудитын илрүүлэлт....................14
4.1 Залруулсан алдаа ....................14
4.3 Албан шаардлага ....................14
4.4 Зөвлөмж ....................14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Хандоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 25

танай _____________-ны № _____________-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ГАНЧУЛУУН ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,424,154.00** | **2,851,538.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 10,424,154.00 | 2,851,538.00 |
| **351** | **Түүхий эд материал** | - | - |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | - |
| 35130 | Эм боох материал | - | - |
| **354** | **Хангамжийн материал** | 10,424,154.00 | 2,851,538.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,651,094.00 | 1,669,338.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,628,200.00 | 832,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 6,144,860.00 | 350,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,165,708,407.00** | **1,252,662,149.41** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,165,708,407.00 | 1,252,662,149.41 |
| **392** | **Биет хөрөнгө** | 981,662,157.00 | 1,068,990,899.41 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 883,025,412.00 | 883,025,412.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (44,158,085.28) | (66,237,127.92) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 129,620,000.00 | 223,717,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (129,620,000.00) | (130,404,145.83) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 202,101,699.74 | 265,270,054.74 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (117,763,510.22) | (152,858,308.55) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 157,699,131.76 | 161,199,131.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (100,073,491.00) | (115,748,448.79) |
| 39217 | Ном | 831,000.00 | 1,026,832.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 129,256,180.00 | 129,256,180.00 |
| 39301 | Программ хангамж | 2,050,000.00 | 2,050,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (643,750.00) | (1,018,750.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 182,640,000.00 | 182,640,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,176,132,561.00** | **1,255,513,687.41** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,176,132,561.00** | **1,255,513,687.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,176,132,561.00 | 1,255,513,687.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 721,451,611.00 | 721,451,611.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 721,451,611.00 | 721,451,611.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (82,443,494.74) | (3,062,368.33) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (82,443,494.74) | (82,443,494.74) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 79,381,126.41 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 537,124,444.74 | 537,124,444.74 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,176,132,561.00** | **1,255,513,687.41** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,749,237,427.00** | **1,809,651,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **64,949,027.00** | **132,476,100.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 64,949,027.00 | 132,476,100.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 64,949,027.00 | 132,476,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,684,288,400.00** | **1,677,174,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,684,288,400.00 | 1,672,455,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,684,288,400.00 | 1,672,455,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,731,599,538.40** | **1,730,269,873.59** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,731,599,538.40** | **1,730,269,873.59** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,680,620,720.62 | 1,698,106,774.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,312,101,940.00 | 1,312,720,048.42 |
| 210101 | Үндсэн цалин | 956,179,839.00 | 1,022,339,312.42 |
| 210102 | Нэмэгдэл | 238,388,420.00 | 202,625,978.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 70,908,000.00 | 51,517,585.00 |
| 210104 | Урамшуулал | 46,625,681.00 | 36,237,173.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 163,582,424.22 | 170,590,179.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 110,916,048.22 | 119,159,501.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,166,594.00 | 13,236,575.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,533,275.00 | 10,515,339.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,633,319.00 | 2,502,337.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,333,188.00 | 25,176,425.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,272,724.00 | 24,269,734.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,595,000.00 | 8,308,323.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,321,424.00 | 11,464,458.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,356,300.00 | 4,496,953.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 76,012,096.00 | 84,566,329.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 32,196,812.00 | 36,763,608.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,146,390.00 | 21,523,685.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,645,444.00 | 15,780,436.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 496,500.00 | 344,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,526,950.00 | 10,154,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,284,920.00 | 14,061,000.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 190,000.00 | 1,141,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,094,920.00 | 12,920,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,696,800.00 | 7,256,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,696,800.00 | 7,256,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,996,210.00 | 9,335,139.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 4,666,615.00 | 4,241,271.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 1,209,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,644,000.00 | 2,644,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 216,825.00 | 214,868.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 247,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,368,770.00 | 678,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,873,606.40 | 74,507,944.59 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 56,373,606.40 | 74,007,944.59 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 50,978,817.78 | 32,163,099.08 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,500,000.00 | 3,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,500,000.00 | 3,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,478,817.78 | 29,163,099.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,478,817.78 | 29,163,099.08 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **17,637,888.60** | **79,381,126.41** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **17,637,888.60** | **79,381,126.41** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 721,451,611.00 | 537,124,444.74 | (100,081,383.34) | 1,158,494,672.40 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **721,451,611.00** | **537,124,444.74** | **(100,081,383.34)** | **1,158,494,672.40** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 17,637,888.60 | 17,637,888.60 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **721,451,611.00** | **537,124,444.74** | **(82,443,494.74)** | **1,176,132,561.00** |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **721,451,611.00** | **537,124,444.74** | **(82,443,494.74)** | **1,176,132,561.00** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 79,981,126.41 | 79,981,126.41 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **721,451,611.00** | **537,124,444.74** | **(3,062,368.33)** | **1,255,513,687.41** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,684,288,400.00** | **1,677,174,900.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,684,288,400.00** | **1,677,455,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,684,288,400.00 | 1,672,455,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,684,288,400.00 | 1,672,455,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтын орлого** | - | 4,719,000.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хувиарилсан хөрөнгө | - | 4,719,000.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,676,950,700.00** | **1,647,752,300.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,625,971,882.22** | **1,615,589,200.92** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,312,101,940.00** | **1,312,720,048.42** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,676,950,700.00 | 1,647,752,300.00 |
| 210101 | Үндсэн цалин | 956,179,839.00 | 1,022,339,312.42 |
| 210102 | Нэмэгдэл | 238,388,420.00 | 202,625,978.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 70,908,000.00 | 51,517,585.00 |
| 210104 | Урамшуулал | 46,625,681.00 | 36,237,173.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 163,582,424.22 | 170,590,179.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 110,916,048.22 | 119,159,501.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,166,594.00 | 13,236,575.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,533,275.00 | 10,515,339.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,633,319.00 | 2,502,337.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,333,188.00 | 25,176,425.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,272,724.00 | 24,269,734.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,595,000.00 | 8,308,323.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,321,424.00 | 11,464,458.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,356,300.00 | 4,496,953.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 76,939,864.00 | 75,901,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 28,605,020.00 | 36,186,164.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,239,400.00 | 15,387,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,645,444.00 | 15,780,436.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 750,000.00 | 344,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,700,000.00 | 8,203,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,081,920.00 | 14,216,400.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 1,582,000.00 | 1,296,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 16,499,920.00 | 12,920,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,696,800.00 | 7,256,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,696,800.00 | 7,256,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,996,210.00 | 9,335,139.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 4,666,615.00 | 4,241,271.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,209,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,644,000.00 | 2,644,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 216,825.00 | 214,868.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 247,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,369,770.00 | 678,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 500,000.00 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **50,978,817.78** | **32,163,099.08** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,500,000.00 | 3,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,500,000.00 | 3,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,478,817.78 | 29,163,099.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,478,817.78 | 29,163,099.08 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,337,700.00** | **29,422,600.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,337,700.00** | **29,422,600.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан | 7,337,700.00 | 29,422,600.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **7,337,700.00** | **29,422,600.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,672,455,900.00 | 1,643,292,800.92 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,672,455,900.00 | 1,643,292,800.92 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,669,455,900.00 | 1,640,292,800.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,323,240,200.00 | 1,312,720,048.42 |
| 210101 | Үндсэн цалин | 1,039,624,000.00 | 1,022,339,312.42 |
| 210102 | Нэмэгдэл | 219,783,500.00 | 202,625,978.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 41,480,400.00 | 51,517,585.00 |
| 210104 | Урамшуулал | 22,352,300.00 | 36,237,173.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 179,069,900.00 | 170,590,179.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 126,202,400.00 | 119,159,501.73 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,216,900.00 | 13,236,575.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,573,500.00 | 10,515,339.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,643,400.00 | 2,502,337.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,433,700.00 | 25,176,425.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,724,200.00 | 24,269,734.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,995,000.00 | 8,308,323.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,522,900.00 | 11,464,458.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,206,300.00 | 4,496,953.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 75,901,300.00 | 75,901,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 26,993,000.00 | 36,186,164.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,642,400.00 | 15,387,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 22,765,900.00 | 15,780,436.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 800,000.00 | 344,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,700,000.00 | 8,203,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 38,920,000.00 | 38,920,000.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 22,500,000.00 | 22,500,000.00 |
| 210602 | Тавилга | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,920,000.00 | 12,920,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,258,500.00 | 7,256,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,258,500.00 | 7,256,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,041,800.00 | 9,335,139.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 6,572,400.00 | 4,241,271.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,209,600.00 | 1,209,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,644,000.00 | 2,644,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 225,900.00 | 214,868.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 247,500.00 | 247,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,043,400.00 | 678,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 500,000.00 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,672,455,900.00 | 1,643,292,800.92 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,672,455,900.00 | 1,643,292,800.92 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,672,455,900.00 | 1,643,292,800.92 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 59.00 | 59.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 6.00 | 6.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 46.00 | 46.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **51.00** | **51.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 25.00 | 25.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 18.00 | 18.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 15.00 | 15.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **4,719,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **4,719,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 4,719,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 4,719,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 4,719,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүх тамгын газар нь иргэний болон хуулийн этгээдийн гаргасан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэж шүүн таслах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, иргэний хэргийн анхан шатны шүүх, захиргааны хэргийн анхан шатны шүүх зэрэг салбар нэгж бүхий байгууллага юм.

Тайлант онд шүүхийн шинэтгэлийг эрчимжүүлж, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шүүгч, ажилтнуудын ажиллаж амьдрах нөхцөл бололцоог

сайжруулах, төрийн албаны дагаж мөрдөх ёс зүйг сахих, эрх ашгийг нь хамгаалахад гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад шүүхийн ерөнхий зөвлөлөөс дотоод аудитын баталгаажуулалт, чанарын хяналтыг тогтмол хийдэг болно. Ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрүэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,672,455.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,724.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,707.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Шүүхийн тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,381.1 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |

| | | | |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Бараа материал | 10,427.2 | 2,851.5 | (7.572.6) |
| Үндсэн хөрөнгө | 1,165,708.4 | 1,252,662.1 | 86,953,7 |
| **Нийт хөрөнгө** | **1,176,132.6** | **1,255,513.7** | **79,381,1** |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,176,132.6 | 1,255,513.7 | 79,381.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,176,132.6** | **1,255,513.7** | **79,381.1** |

Бараа материалын данс 7,572.6 мянган төгрөгөөр буурсан нь түлш, шатах тослох материалын эхний үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалан буурсан байна.

Тайлант хугацаанд худалдан авсан 25,922.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,500.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, шилжүүлэн авсан 94,097.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 37,245.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн орлого үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өсөхөд голлон нөлөөлсөн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,255,513.7 мянган төгрөг болж 79,381.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Шүүхийн тамгын газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,672,455.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,672,455.9 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,643,292.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжиж, урсгал үйл ажиллагаанд 1,614,129.7 мянган төгрөгийг зарцуулж, 29,163.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,614,129.7 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 10,520.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 8,479.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7,454.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2,708.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн санхүүжилтээс 4,719.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт санхүүжилтээр авсан 4,719.0 мянган төгрөгийг камер авахад зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шүүхийн тамгын газар нь 2021 онд нийт 1,156,534.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 1,156,534.0 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Аудитын явцад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 1,659,403.7 мянган төгрөгийн 12 гүйлгээ, зардлын 123,019.8 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлсэн болно.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн хувь хүнээс авсан ажил үйлчилгээний хөлсөнд НДШ, ХХОАТ тооцоогүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэмэлт амралтын хоногийг олгоогүй, амралтын мөнгийг дутуу тооцсон, мөн тус иргэний цалингаас ХХОАТ суутган тооцсон нь “Нийгмийн даатгалын тухай”, “Хувь хүний орлогын албан татварын тухай”, “Хөдөлмөрийн тухай” хуулиудын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 4,134.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Мянган төгрөгөөр

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Акт | - | - | - | - | - | - | |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | |
| Зөвлөмж | 2 | 4,134.1 | 2 | 4,134.1 | 0 | 0 | |
| Нийт дүн | 2 | 4,134.1 | 2 | 4,134.1 | 0 | 0 | |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар анхаарал татахаар чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,027.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс тус мөнгөн дүнгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад залруулсан алдаа байхгүй.

### 4.3 Албан шаардлага

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Хувь хүнээс авсан ажил үйлчилгээний хөлсийг шууд олгож байгаа нь “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 32.2-р зүйл, “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн 6-р зүйлийн шалгуурт нийцэхгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Хувь хүнээс авч байгаа ажил үйлчилгээний хөлсийг олгохдоо холбогдох хуулиудын дагуу шимтгэл, татварыг тооцож олгож байх.

***2. Зардлын данстай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний цалингаас ХХОАТ суутган тооцсон нь “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн 22.1.2 зүйлийн шалгуурт нийцэхгүй байна.

*2.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй орлогод ХХОАТ ногдуулахгүй байх.

***3. Зардлын данстай холбоотой асуудал***

*3.1. <u>Илрүүлэлт:</u>*

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэмэлт амралтын хоногийг олгоогүй нь “Хөдөлмөрийн тухай” хуулийн 99.4 зүйлийн шалгуурт нийцэхгүй байна.

*3.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу амралтыг олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Шүүхийн тамгын газар | 3 | 5027.2 | | | | | | | 3 | 5,027.2 |
| **Дүн** | | **3** | **5027.2** | | | | | | | **3** | **5027.2** |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

<u>БЭЛТГЭСЭН:</u>

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР: Б.ПҮРЭВСҮРЭН

<u>ХЯНАСАН:</u>

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР,ЗАХИРАЛ : Д.МЯГМАРСҮРЭН

<u>АНХАН ШАТАНД ХЯНАСАН:</u>

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

<u>ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:</u>

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

6117143690
ФАА0073 9042806